



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2017 оны 04 сарын 25 өдөр

Дугаар 60

Номгон

Хөрөнгийн тухай

Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит төсвийн байгууллага болон төсөвт үйлдвэрийн газар эд хөрөнгө олж авах, бүртгэх, дуудлагаар худалдах, шилжүүлэх, актлах журам”-ын 1.6 дахь заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Баянхонгор сумын Наранмандал өрхийн эрүүл мэндийн төв, Баянбулаг сумын Засаг даргын Тамгын газар, Гурванбулаг сумын Засаг даргын Тамгын газар, Эрүүл мэндийн төвийн үндсэн хөрөнгөд тус тус бүртгэлтэй автомашинуудын худалдах доод үнийг хавсралтаар баталсугай.

2. Баянбулаг сумын Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 1987 онд ашиглалтад орсон 672 м2 талбай бүхий 2 айлын 4 өрөө орон сууцыг газрын хамт мэргэжлийн үнэлгээчин болон үнэлгээний компаниар бодитой үнэлүүлж, худалдах доод үнийг тогтоож дуудлагаар худалдсугай.

3. Хавсралтад заасан автомашинуудын дуудлага худалдааг 2017 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 11 цагт, мөн 2 айлын орон сууцны үнэлгээг тогтоолгосноос хойш 14 хоногийн дотор дуудлага худалдааг зарлаж аймгийн Засаг даргын Тамгын газрын 117 тоот өрөөнд зохион байгуулсугай.

4. Дуудлага худалдаанаас орох орлогыг Төрийн сан банкин дахь Орон нутгийн өмчийн газрын **100030051006** тоот дансанд төвлөрүүлсүгэй.

5. “Чандмань-Баянхонгор” ХК-ний хөрөнгөд бүртгэлтэй 2009 онд ашиглалтад орсон, ашиглалтын хугацаа дууссан Ковш ZL50TS2510050 маркийн механизмыг акталж данснаас хасч тус компанид сэлбэгээр ашиглуулсугай.

116796

6. Хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг зохих журмын дагуу хийж, хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалтад хяналт тавьж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга /Ч.Мөнхцэцэг/-д даалгасугай.

7. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /С.Үнэнбуян/-д даалгасугай.

ДАРГА

A handwritten signature in blue ink is written over a red rectangular official stamp. The stamp contains Mongolian text, including the name of the aimag and the title of the official. The signature is written in a cursive style.

Ц.ОТГОНБАЯР



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2017 оны 04 дүгээр сарын  
18-ны өдрийн 60-дугаар тогтоолын хавсралт

ХУДАЛДАХ АВТОМАШИНУУДЫН ЖАГСААЛТ

№	Аймаг, сумын нэр	Байгууллагын нэр	Тээврийн хэрэгслийн төрөл	Марк	Улсын		Ашиглалтад орсон огноо	Тээврийн хэрэгслийн			Дуудлагаар худалдах доод үнэ	Тайлбар
					сери	дугаар		арлын дугаар	моторын дугаар	моторын эзлэхүүн /см <sup>3</sup> /		
1	Баянхонгор	Наранмандал өрхийн эмнэлэг	Суудлын автомашин	Toyota, vitz	БНХ	20-88	2010.02.01	scr100065346	0	990В	1500000.0	Элэгдлээ 100% нөхсөн монголд 2008 онд орж ирсэн
2	Баянбулаг сум	Засаг даргын Тамгын газар	Суудлын автомашин	УАЗ-31519-017	БНА	00-12	2009.01.01	80513599	8.1E+07	2890В	1500000.0	Элэгдлээ 100% нөхсөн 2008 онд үйлдвэрлэгдсэн
3	Гурванбулаг сум	Засаг даргын Тамгын газар	Суудлын автомашин	Ланд 80	БНА	92-20	2009.01.01	0024060	lfz004180	В4470	2500000.0	Сүүлийн 5 жилд засвар үйлчилгээ хийгээгүй 1992 оны автомашин
4	Гурванбулаг сум	ЭМТ	Суудлын автомашин	Уаз-469 түргэн тусламжийн автомашин	БНА	58-31	2000.02.25				1000000.0	Сүүлийн 5 жилд засвар үйлчилгээ хийгээгүй 2000 оны автомашин
			Дүн								6500000	